



Нийгмийн давхраажилт тогтох шалтгаан юу вэ?



Карл Маркс
1818 — 1883

КАПИТАЛ, КОММУНИСТ НАМЫН ТУНХАГ ЗЭРЭГ БҮТЭЭЛДЭЭ НИЙГМИЙН ЯЛГАРЛЫН АСУУДЛЫГ АВЧ ҮЗСЭН. ТЭРЭЭР АНГИ ХООРОНДЫН ХАРИЛЦААГ МӨЛЖЛӨГИЙН ШИНЖТЭЙ ГЭЖЭЭ. КАПИТАЛИСТ НИЙГМИЙН ҮЕД ӨМЧЛӨГЧ БАЯЛГИЙН ИХЭНХ ХУВИЙГ, ХАРИН АЖИЛЧИД ӨЧҮҮХЭН ХУВИЙГ ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛС НЭРИЙН ДОР МӨЛЖЛӨГӨД ӨРТДӨГ.




М. ВЕБЕР
1864-1920

“АНГИ, СТАТУС, НАМ” 1920 БҮТЭЭЛДЭЭ ДАВХРААЖИЛТЫН АСУУДЛЫГ ХӨНДСӨН. АНГИЙН ЯЛГАРАЛД ӨМЧӨӨС ГАДНА ОРЛОГО, ЭРХЭЛЖ БУЙ АЖИЛ МЭРГЭЖИЛ ЧУХАЛ ГЭЖ ҮЗСЭН. ТҮҮНЧЛЭН ТЭРЭЭР ДАВХРААЖИЛТЫН СУДАЛГААНД СТАТУСЫН БҮЛЭГ, НАМЫН ЯЛГАРЛЫН АСУУДЛЫГ СУДАЛСАН. СТАТУСЫН БҮЛЭГ НЬ НИЙГМИЙН БҮЛГҮҮДИЙН НЭР ХҮНДИЙН ЯЛГААТАЙ ХОЛБООТОЙ. НАМ НЬ АШИГ СОНИРХЛООРОО ЯЛГААТАЙ БҮЛЭГ ХҮМҮҮС БӨГӨӨД ЭРХ МЭДЛИЙН ЯЛГАРЛЫГ ИЛТГЭНЭ.


Нийгмийн давхраажилт тогтох шалтгаан юу вэ?



Э.Дюркгейм нарын социологичид анхнаасаа нэр хүнд, ажил мэргэжлийн байр суурийн ялгарлыг нийгмийн давхраажилтын суурь шалтгаан гэж үздэг. Тэд хөдөлмөрийн хуваарь нийгмийн зохион байгуулалтын үндэс болохын зэрэгцээ тэгш бус байдалд хүргэх үндсэн шалтгаан гэжээ.



Т.Парсонс тухайн нийгэмд зонхилж байгаа үнэлэмжийн дагуу хүмүүс бусад хүмүүсээрээ үнэлэгдэж, зэрэглэгдэж байдаг. Тэгэхээр бүх нийгэмд байр суурийн нэр хүндээс хамаарсан шатлал оршин байдаг



Л.Уорнер Тэрээр хувь хүний ангийн харьяаллыг нийгэм-эдийн засгийн үзүүлэлтээр хэмжих бус, харин бусад хүмүүсийн зүгээс үнэлэх нэр хүндийн субъектив үнэлгээ, хүндлэлээр хэмжих загварыг боловсруулсан юм. Тодруулбал, дэлгүүрийн эзэн эмчийг нэр хүндээр өөрөөсөө илүү гэж үзвэл түүнийг дэлгүүрийн эзнээс дээд ангид оруулах замаар судална. Энэхүү аргачлалыг жижиг орон нутгийн хувьд ашиглаж болох ч, томоохон хот сууринд ашиглахад хүндрэлтэй юм.

Нийгмийн давхраажилт тогтох шалтгаан юу вэ?

Орчин үед нийгмийн давхраажилтыг хэрхэн судалж байна вэ?

Зөрчилдөөний онол:

- Марксын ангийн ялгаа нь ашиг сонирхлын ялгаа, улмаар зөрчилд хүргэдэг гэсэн санаанд тулгуурладаг ч ангийн ялгарлыг өмчийн гэхээсээ илүү эрх мэдлийн ялгаатай түлхүү холбон үздэг.
- Ашиг сонирхлын ялгаа нь ЗБ-сан шинжтэй эрх мэдлийн /бюрократ байгууллага болон улс төрийн/ бүтцэд тусгалаа олдог.
- Орчин үед бюрократ байгууллагад эрх мэдэл ажилтнуудад тэгш бусаар хуваарилагдсан байдаг ч ноёрхогч хийгээд дагагч хэмээх 2 ангид хуваагдахад хүргэдэг.

Нийгмийн давхраажилт тогтох шалтгаан юу вэ?

Шүүмжлэлт онол:

Е.О.Райт. Өмчөөс гадна орлого, эрхэлж буй ажил мэргэжил гэсэн бусад хүчин зүйлсийг чухалчилж үзсэн.

Бүтэц чиг үүргийн онолын төлөөлөгчид:

Э.Дюркгейм. Нэр хүнд ажил мэргэжлийн байр суурийн ялгарлыг нийгмийн давхраажилтын суурь шалтгаан гэж үздэг. Тэр хөдөлмөрийн хуваарь нийгмийн зохион байгуулалтын үндэс болохын зэрэгцээ тэгш бус байдалд хүргэх үндсэн шалтгаан гэжээ.

Т.Парсонс Нийгэмд зонхилж байгаа үнэлэмжийн дагуу хүмүүс бусад хүмүүсээрээ үнэлэгдэж зэрэглэгдэж байдаг. Тэгэхээр бүх нийгэмд байр суурийн нэр хүндээс хамаарсан шатлал оршин байдаг хэмээн үздэг.

Нийгмийн давхраажилт тогтох шалтгаан юу вэ?

Бүтэц чиг үүргийн онолын төлөөлөгчид:

Дэвис ба Мур. Нэг хэсэг байр суурь нь бусдаас илүү чухал бөгөөд өндөр ур чадварыг шаарддаг, хүмүүсийн сонирхлыг татахын зэрэгцээ илүү хүндлэл хүлээж байдаг.

Л.Уорнер. Бүтэц чиг үүргийн онолын үүднээс Янки хотыг судалж, хувь хүний ангийн харьяаллыг нийгэм, эдийн засгийн үзүүлэлтээр хэмжих бус, харин бусад хүмүүсийн зүгээс үнэлэх нэр хүндийн субъектив үнэлгээ хүндлэлээр хэмжих загварыг боловсруулсан юм.

Дункан. Ажил мэргэжлийн нэр хүндийг тодорхойлохдоо объектив шалгуурыг ашиглах үүднээс эдийн засгийн индексийн аргачлалыг боловсруулсан. Энэ нь ажил мэргэжлийн нэр хүндийн зэрэглэлийг тухайн хүний боловсрол, орлогын хэмжээгээр тодорхойлдог.